



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2020 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/04

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2019 оны 01 дүгээр тэмдэглэл, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн 2020 оны батлагдсан төсвийн хүрээнд хийгдэх хот нийтийн аж ахуйн ажлын төсвийн задаргааг хавсралт ёсоор баталсугай.

2. Батлагдсан хөрөнгийн хүрээнд Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын хэлтэс /С.Аригуун/-т, гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг хангаж ажиллахыг Хот тохижилтын газар ОНӨААТҮГ /Б.Бямбадорж/-т тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаалын хавсралтаар батлагдсан нийт 2.932.474.825 / хоёр тэрбум есөн зуун гучин хоёр сая дөрвөн зуун далан дөрвөн мянга найман зуун хорин тав / төгрөгийг хот тохижилтын төсөвлөгдсөн зардлаас гүйцэтгэлээр санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч Б.Цэрмаад зөвшөөрсүгэй.

4. Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-тай байгуулсан хот нийтийн аж ахуйн ажилд өдөр тутмын хяналт тавьж мэдээллээр хангаж ажиллахыг хяналтын төрийн бус байгууллагуудад үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2020 оны *Одоо* сарын *10* өдрийн
Хот бүрэлд тушаалын хавсралт

НИЙСЛЭЛД 2020 ОНД ХИЙГДЭХ ХОТ НИЙТИЙН
АЖ АХУЙН АЖЛЫН ТӨСВИЙН ЗАДАРГАА

| Д/д | Ажлын нэр | Шаардагдах хөрөнгө |
|-------------|--|----------------------|
| 1 | Төвлөрсөн хогийн цэгийг хөрсөөр дарж булах | 2.080.000.000 |
| 2 | Хогийн төвлөрсөн цэгүүдийн ариутгалын ажил | 200.000.000 |
| 3 | Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн тоосжилтыг бууруулах зорилгоор зам талбай, агаар чийгшүүлэх, автозам тусгаарлах шар хайс угаах | 195.449.600 |
| 4 | Алтан Өлгийн оршуулгын газрын арчлалт хамгаалалтын ажил | 88.735.225 |
| 5 | Нийтийн бие засах газрын ашиглалтын болон ажилчдын зардал | 126.540.000 |
| 6 | Био 00-н үйлчилгээний ажил | 179.100.000 |
| 7 | Устасан золбин нохой, муурын сэг зэмийг устгах, булшлах ажил | 62.650.000 |
| Нийт | | 2.932.474.825 |